

## **БЭСТ ТООЛ БЮЛДИНГ ХХКОМПАНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Бэст тоол бюлдинг ХХК нь Монгол улсын хөгжил дэвшлийн нэг хэсэг болох барилгын салбарыг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэрээ оруулахаар 2012 онд 187,337,267 төгрөгийн дүрмийн сантайгаар байгуулагдаж, шилдэг, чадварлаг мэргэжилтнүүдийг эгнээндээ нэгтгэн хөгжингүй орны бүтээн байгуулалтын арга технологийг эх орондоо нэвтрүүлэх, барилгын чанар, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг тэргүүн эгнээнд тавьж бусад өрсөлдөгч компаниудад үлгэр дуурайлал болохуйц үндэсний шилдэг тэргүүлэх компани болох зорилтыг тавин ажиллаж байна.

Бэст тоол бюлдинг ХХК нь дараах тусгай зөвшөөрөлөөр үйл ажиллагаа явуулж байна.

Үүнд:

1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
2. Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн, барилгын ажил
3. Ган бүтээцэн барилгын ажил
4. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
5. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт
6. Холбоо дохиолол, интернет, компьютерийн сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт
7. Гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт

Манай компани нь 70 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд, Монгол Улсын барилгын зөвлөх архитектор-1, барилгын зөвлөх инженер -1, дулааны зөвлөх инженер-1, барилга угсралтын мэргэшсэн инженер-2, цахилгаан хангамжийн мэргэшсэн инженер-2, тэргүүлэх төсөвчин-1, 20 гаруй өндөр мэргэжлийн инженер техникийн ажилтан, 50 гаруй барилгын мэргэшсэн, мэргэжилтэй ажилчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Манай компаний ажилчид нь 2-30 хүртэлх жил, тухай салбартаа он удаан жил ажилласан дадлага туршлагатай хамт олноос бүрдсэн бөгөөд тэдний хөдөлмөр зүтгэлийг Монгол Улсын засгийн газраас үнэлж Алтангадас одонгоор-1, хөдөлмөрийн хүндэт медалиар-2, барилгын салбарын тэргүүний ажилтан-3, аймаг, орон нутгийн жуухаар-5 хүн тус тус шагнуулсан байна.

Мөн манай компани нь сүүлийн үеийн барилгын салбарт ашиглагдаж байгаа дэвшилтэд техник технологи, тоног төхөөрөмжөөр материаллаг баазаар бүрэн бэхжүүлсэн.

Цаашид Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлэх, 100000 айл орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлж, нэг квадрат метр орон сууцны үнийн өсөлтийг бууруулахад доривтой хувь нэмэрээ оруулж залуу гэр бүлийг дэмжих, Улсынхаа бүтээн байгуулалтанд гар бие оролцон их бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр санаа нийлсэн шилдэг, чадварлаг хамт олонтойгоор ажиллаж байна.